



**Ажлын
байранд
галын
аюулгүй
байдлыг
хангах**

Хууль эрх зүйн орчин

Галын аюулгүй байдлыг хангах асуудал 1999 онд батлагдсан. “Галын аюулгүй байдлын тухай” Монгол улсын хуулиар зохицуулагдаж байна.

15-р зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаарх иргэдийн эрх, үүрэг

15.1. Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараах эрхтэй байна:

15.1.1. гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтооход биечлэн оролцох;

15.1.2. гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээ авах;

15.1.3.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах.

Хууль эрх зүйн орчин

- 15.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараах үүрэгтэй байна.
- 15.2.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжмийг сахин биелүүлэх
- 15.2.2. гал түймэр гарч байгаа тохиолдолд гал түймэртэй тэмцэх байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- 15.2.3. гал түймэр унтраах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 15.2.4. гал түймрийн талаарх зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх.

Хууль эрх зүйн орчин

16 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

16.1. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж дараахь үүрэг хүлээнэ:

16.1.1. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг чандлан сахих;

16.1.2. тухайн аж ахуйн нэгж байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах;

16.1.3. галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, хэм хэмжээ, стандартыг хангаж ажиллах;

16.1.4. барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх болон хийц, бүтээц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлахдаа гал түймэртэй тэмцэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах;

Хууль эрх зүйн орчин

- 16.1.5. ажилтан, ажилчдынхаа гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;
- 16.1.6. гал унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 16.1.7. шинээр баригдаж байгаа барилга, байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэргийг байрлуулан ашиглахдаа гал түймэртэй тэмцэх байгууллагын мэргэжлийн дүгнэлтийг гаргуулах.

Хууль эрх зүйн орчин

16.2.галын аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж байгууллага дараахь эрх эдэлнэ:

16.2.1. галын аюулгүй байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зааварчилга, зөвлөгөө авах;


16.2.2. гал түймрийн аюулаас хамгаалах зорилгоор гал унтраах гэрээт нэгж ажиллуулах.

Галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг, хариуцлагыг Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуулиар зохицуулдаг.

Гал бүрдүүлэгч

Галд нөлөөлдөг 3 хүчин зүйл

1. Хүчилтөрөгч



2. Дулааны эх үүсвэр

3. Түлш

Гал бүрдүүлэгч

1. Хүчилтөрөгч

- агаарт ойролцоогоор 21% байдаг
- гал асаж шатахад 16% шаардлагатай

2. Дулааны эх үүсвэр

- ил гал
- халуун гадаргуу
- оч
- цахилгааны эх үүсвэр
- үрэлт
- даралтат хий

3. Түлш

- хий / угаарын хий, байгалийн хий, устөрөгч, ацетилин, пропан бусад /
- шингэн / будаг, лак, бензин, шатах тослох материал, бусад
- хатуу биет / мод, цаас, нүүрс, хуванцар, хөөсөнцөр гэх мэт/

Гал нь шатамхай материалын төрлөөс хамааран А, В, С, Д гэсэн дөрвөн зэрэглэлд ангилагдана.

Галын зэрэглэл - А

Галын зэрэглэл	А
Шатамхай материалын ангилал	Органик гаралтай хатуу биет
	Мод, цаас, даавуу, резин, хуванцар эдлэл гэх мэт
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хогийг үргэлж цэвэрлэж зориулалтын саванд хийж, саваа өдөр бүр цэвэрлэж байх Тос арчсан даавууг галын эх үүсвэрүүдээс хол орших тагтай төмөр саванд хадгалж бай Тостой гараар галын эх үүсвэр бүхий эд зүйлд бүү хүр
Гал унтраагуурын төрөл	-Химийн хөөс -Усан хөөс

Галын зэрэглэл - В

Галын зэрэглэл	В
Шатамхай материалын ангилал	Шатамхай шингэн
	Бензин, дизель түлш, тос, будаг, лак гэх мэт
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Сайтар агааржуулагдсан орчинд ашиглах Оч хаях эх үүсвэрээс хол хадгалах Барилга байгууламж дотор 100 литрээс илүү бүү хадгал Шатамхай шингэн хадгалах агуулах бусад барилгаас 7 м-ээс багагүй зайд байх Зөөврийн саванд хадгалах бол уг савны хэмжээ 20 литр хүртэл байх шаардлагатай
Гал унтраа-гуурын төрөл	-Нунтаг хөөс

Галын зэрэглэл - С

Галын зэрэглэл	С
Шатамхай материалын ангилал	Цахилгаанаар ажилладаг техник
	Чийдэн, багаж хэрэгсэл, хөдөлгүүр
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	<p>Тэжээлийн утсыг гэмтэлгүй байлга</p> <p>Тохирсон гал хамгаалагч хэрэглэ</p> <p>Ачаалал хэтрүүлж болохгүй</p> <p>Нэг залгуур нэг хэрэглэгч залга, давхар хос холболт хийж болохгүй . Халж байгаа эсэхэд тогтмол хяналт тавь</p> <p>Цахилгаан техник тоног төхөөрөмжөөс үнэр гарч буй эсэхэд тогтмол хяналт тавь</p>
Гал унтраагуурын төрөл	-Нүүрсхүчлийн хий

Галын зэрэглэл - Д

Галын зэрэглэл	Д
Шатамхай материалын ангилал	Шатамхай металлууд
	Магни, титан, поташ
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Аюулгүй ашиглах дүрмийг чанд мөрдөх
Гал унтраа-гуурын төрөл	-Усан хөөс

Гал унтраагуурын бүтэц



Гал унтраагуур ажиллуулах заавар



Нүүрсхүчлийн хийн гал унтраагуул

Зориулалт:

Бүх төрлийн шатах бодис, 1000В хүртэл хүчдэл бүхий цахилгаан тоног төхөөрөмжид гарсан бага хэмжээний галыг унтраахад зориулагдсан.

Ажиллуулах дараалал:

Гал унтраагуулыг ажиллуулахдаа зүүн гараараа бариулаас барьж баруун гараараа цацруулагч хоолойг галын голомт руу аль болохоор ойртуулан чиглүүлж түгжээг мултлан бариулыг чанга атгана. Ингэхдээ баллоныг хэвтээ байдалд хүртэл хазайлгаж болохгүй.

Гал унтраагуур ажиллуулах заавар

ОХВП-Химийн хөөсөн гал унтраагуул

Зориулалт:

Шатах хатуу бодис, хялбар авалцан асах шингэний/1 м.кв-аас ихгүй талбайтай/галыг унтраахад зориулагдсан.


Ажиллуулах дараалал:

Гал унтраах бодисын цоргыг нээлттэй эсэхийг шалга

Лацыг авч хөшүүргийг тултал эргүүл/180 хэм/

Гал унтраагуулыг эргүүлэн доош харуулж сэгсэр

Галын голомт руу унтраах бодисыг цац



Гал унтраагуур ажиллуулах заавар



ОПУ-Нунтаг гал унтраагуул

Зориулалт:

Нефтийн бүтээгдэхүүн, хялбар авалцан асах шингэн, хатуу бодис, материал, 1000В хүртэл хүчдэл бүхий цахилгаан тоног төхөөрөмжид гарсан галыг унтраахад зориулагдсан.

Ажиллуулах дараалал:

Лацыг авна

Гал унтраагуулын хошууг гал руу чиглүүлнэ

Бариулыг атгах эсвэл товчлуурыг дарна

.5 секундйн дараа гал унтраах ажиллагаа эхэлнэ

Галтай тэмцэхэд бэлэн байх

- Гарах хаалга “гарц” гэсэн ослын гэрэлтүүлэгтэй байна
- Хүмүүс явах зам тэмдэг тэмдэглээстэй байна
- Гал унтраагуурын байршил, ажиллах зарчмыг мэддэг байна
- Аюулыг мэдээлэх дуут дохиололтой байна.
- Утаатай орчноос зайлсхийх

Галын аюулаас дүрвэн гарах

- Галын аюул гарсан үед аврах гарц, хаалга хаана буйг сана
- Өрөөнөөс гарч буй сүүлийн хүн хаалгыг түгжилгүй хаагаад л орхих хэрэгтэй. Учир нь гал сөнөөгчид аврах ажиллагаа хийхэд нь саад болж болзошгүй
- Хамгийн ойрын гарцаар гар
- Ямар ч тохиолдолд цахилгаан шат бүү хэрэглэ
- Утаа болон хорт хийнээс сэргийлэхийн тулд аль болох тонгойж доогуур яв. Шалтай ойр байх тусам агаар цэвэр байдаг тул шаардлагатай бол мөлх
- Боломжтой бол ам, хамраа даавуугаар халхалвал амьсгалахад амар болно.

Хэрэв та галд өртвөл

- Бүү сандар. Саруул ухаанаар бодох нь амиа аврахад чинь тус болно.
- Хаалттай байгаа хаалгыг гарын араараа тэмтэрч мэдрээгүй бол бүү онгойлго. Хаалга халуун бол өөр гарц хай. өөр гарц үгүй тохиолдолд хаалганы зай завсрыг боломжтой зүйлээрээ халхал
- Амьсгалах боломжтой байгаа бол хаалгатай аль болох ойр байж өрөөг агааржуулахын тулд цонхыг хагал
- Хэрэв хувцас чинь галд өртвөл зогс, хэвт, өнхөр, гүйж болохгүй
- Таны хамтрагсдын нэг галд өртвөл хүрэм, хөнжил, гудас мэтийн зүйлээр түүнийг ороо

АЖЛЫН БАЙРАНД ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ МЕНЕЖМЕНТ




Галын зэрэглэл	А	В	С	Д
Шатамхай материалын ангилал	Органик гаралтай хатуу биет	Шатамхай шингэн	Цэхижганаар ажилладаг техник хэрэгсэл	Шатамхай металлууд
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Мод, цаас, даавуу, резин, нийлэг болон хуванцар эдлэл гэх мэт - Хогийг үргэлж цэвэрлэж зориулалтын саванд хийж, саваа одор бүр цэвэрлэж байх - Тос арчсан даавууг галын эх үүсвэрүүдээс хол орших тэгтэй төмөр саванд хадгалж бай	Бензин, дизель түлш, тос, будаг, лак гэх мэт - Сайтар агааржуулагдсан орчинд ашиглах - Оч хаях эх үүсвэрээс хол хадгалах - Барилга байгуулах дотор 100 литрээс илүү бүү хадгал - Шатамхай шингэн хадгалах агуулах бусад барилгаас 7 м-ээс багагүй зайд байх - Зөөврийн саванд хадгалах бол уг савны хэмжээ бага /20л/ байх шаардлагатай	Машина, чийдэн, багаж хэрэгсэл, хөдөлгүүр гэх мэт - Тэжээлийн утсыг гэмтэлгүй байлга - Тохирсон гал хамгаалагч хэрэглэ - Ачаалал хэтрүүлж болохгүй - Нэг залгуурт нэг хэрэглэгч залга - Давхар, хос холболт хийж болохгүй - Цэхижгана техник тоног төхөөрөмшөөс үнэр гарч буй эсэхэд тогтмол хяналт тавь	Магни, титан, поташ - Аюулгүй ашиглах дүрнийг чанд мөрдөх
Гал унтраагуурын төрөл	-Хийний хөөс -Усан хөөс	-Нунтаг хөөс	-Нүүрс хүчлийн хий	-Усан хөөс
Ашиглах заавар	<p>А-түгжээг ав: Ч-хошууг чиглүүл: А-хөшүүргийг атга: З-хошууг займчуул</p>			
Галын аюулын үед галтай тэмцэхэд бэлэн байх	<ul style="list-style-type: none"> - Гарах хаалга "гарц" гэсэн аваарын гэрэлтүүлэгтэй байна - Хүмүүс цвах зам тэмдэг тэмдэглэсэстэй байна - Гал унтраагуурын байршил, ажиллах зарчмыг мэддэг байна - Аюулыг мэдээлэх дуут дежнэлалттой байна - Утаатай орчноос зайлсхийх санаачлагатай бай - Ил гал гаргах, тамхи татахыг хориглосон тэмдэг тавь - Дэлбэрэх, шатах зүйлд шаардлагатай шошго хий 			
Галын аюулын үед яаж дүрвэн гарах вэ	<ul style="list-style-type: none"> - Бүү сандар. Саруул ухаанаар бодох нь амиа аврахад чинь тус болно. - Хаалттай байгаа хаалгыг гарын араараа тэмтэрч мэдрээгүй бол бүү онгойлго. Хаалга халуун бол өөр гарц хай. - Өөр гарц үгүй тохиолдолд хаалганы зай завсрыг боломжтой зүйлээрээ халхал. - Амьсгалах боломжтой байгаа бол хаалгатай аль болох ойр байж өрөөг агааржуулахын тулд цонхыг хагал. - Хэрэв хувцас чинь галд өртвөл зогс, хээт, өнхөр, боллоцоотой зүйлээр биеэ ороо, гүйж болохгүй. - Таны хамтрагсдын нэг галд өртвөл хүрэм, хөнжил, гудас мэтийн зүйлээр түүнийг ороо. 			
Хэрэв та галд өртвөл	<ul style="list-style-type: none"> - Өрөөнөөс гарч буй сүүлийн хүн хаалгыг түгжилгүй хаагаад л орших хэрэгтэй. Учир нь гал сөнөөгчид аврах ажиллагаа хийхэд нь саад болж болзошгүй - Хамгийн ойрын гарцаар гар - Ямар ч тохиолдолд цэхижгана шат бүү хэрэглэ - Утаа болон хорт хийнээс сэргийлэхийн тулд аль болох тонгойж доогуур яв. Шалтай ойр байх тусам агаар цэвэр байдаг тул хэрэгтэй бол мөлх - Боломжтой бол ам хамраа даавуугаар халхалаал амьсгалахад амар болно 			

С/р	№	2008	2009
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			
11			
12			



Галын аюулгүй байдлыг хангах бүлгийн гишүүд



**Анхаарал тавьсанд
баярлалаа**